

ТОГТВОРТОЙ БИЧИЛ УУРХАЙ ТӨСӨЛ

БАРИМТ МЭДЭЭЛЭЛ

Төслийн нэр:

Тогтвортой бичил уурхай төсөл

Хугацаа:

2015 – 2018

Төсөв:

Швейцарийн Холбооны Улс -
6,000,000 шв.франк
Монгол Улс - 500,000 шв.франк

Зорилтот бүлэг:

- Хувиараа ашигт малтмал олборлогчид (ХАМО)
- Бичил уурхайчид
- Бичил уурхайн нөхөрлөлүүд
- Бичил уурхайн ТББ-ууд
- Төв болон орон нутгийн төрийн байгууллагууд

Зорилтот бүс нутаг:

Монгол Улсын болон бичил уурхайн мэдлэгийн төвөөр дамжуулан олон улсын хамтрагч байгууллагуудтай хамтран ажиллана.

Швейцарийн хөгжлийн агентлагийн Тогтвортой бичил уурхай төсөл нь 2005 оноос хойш Монгол Улсад бичил уурхайг зохион байгуулах, албажуулах, байгаль орчинд ээлтэй бичил уурхайн сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, оролцогч талуудын хариуцлагатай бичил уурхайн талаарх ойлголтыг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулж ажиллаж байна. Бичил уурхайн салбар нь орон нутгийн иргэд амьжиргаагаа залгуулахад чухал ач холбогдолтой бөгөөд энэ салбарт хэрэгжиж буй Тогтвортой бичил уурхай төслийн (ТБУТ) үр шимийг бичил уурхай эрхэлж буй 60 гаруй мянган иргэд болон тэдний гэр бүлийнхэн хүртэж байна. ТБУТ нь (I) бичил уурхайд хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлэх, (II) алтны нийлүүлэлтийн сүлжээг албажуулахад дэмжлэг үзүүлэх, (III) Монголын бичил уурхайн мэдлэгийн төв байгуулахад анхаарч байна.



© SDC / SAM project

ҮНДЭСЛЭЛ

Бичил уурхайн үйл ажиллагаа Монгол Улсад эдийн засгийн шилжилтийн үе болон удаа дараалан тохиолдсон ган, зудын үр дагавраар бий болсон ажилгүйдэл, ядуурлаас улбаалан 20 гаруй жилийн өмнөөс эхэлжээ. Гол төлөв хөдөө орон нутгийн орлого багатай иргэд алт, нүүрс, жонш зэрэг ашигт малтмал олборлож амьжиргаагаа залгуулах хэрэгсэл болгосоор ирсэн байна. Хэдийгээр энэ энэ салбарын хөгжилд тодорхой ахиц гарч

байгаа боловч тэгш бус байдал, нийгмийн ялгаварлан гадуурхалт, хүний эрхийн зөрчилтэй холбоотой асуудлууд байсаар байна. ТБУТ-ийн дэмжлэг, нөлөөллийн үйл ажиллагааны үр дүнд 2010 оны долдугаар сард Бичил уурхайн эрх зүйн орчин бий болсноор Монгол Улсад Бичил уурхайн салбарыг албан ёсоор хүлээн зөвшөөрсөн гэж үздэг. Үүнээс хойш олон мянган бичил уурхайчид зохион байгуулалтад орж, албан ёсоор бичил уурхай эрхэлж байна.

ШХА-ийн зорилго:

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн эрх тэгш, тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулахыг зорино.

ЗОРИЛГО

Тогтвортой бичил уурхай төслийн 4 дэх үе шат нь эдийн засгийн хувьд тогтвортой, байгаль орчны хариуцлагатай, хүний эрхэд суурилсан Монгол Улсын бичил уурхайн салбар нь бичил уурхайн талаарх олон улсын сайн туршлагаас суралцах, үр шимийг хүртэх, хувь нэмэр оруулна.

ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХҮЛЭЭГДЭЖ БҮЙ ҮР ДҮН:

ТБУТ нь өөр хоорондоо уялдаа бүхий гурван бүрэлдэхүүн хэсэгтэй. Үүнд:

- **Хүний эрхэд суурилсан бичил уурхайн бодлого ба бичил уурхайчдыг дэмжих үйл ажиллагаа:** Бичил уурхайчдын эрхийг хүндэтгэх, хамгаалах, хэрэгжүүлэхтэй холбоотой төрийн чадавхыг бэхжүүлэх, бичил уурхайчид эрхээ шаарддаг, нийгэм болон байгаль орчны хувьд хариуцлагатай үйл ажиллагаа явуулдаг болох зэргээр хүний эрхэд суурилсан хандлагыг Монгол Улсын бичил уурхайн бүх үйл ажиллагаанд тусгана.
- **Нийлүүлэлтийн албан ёсны сүлжээнд оролцогч талуудын эдийн засгийн чадавхыг бэхжүүлэх:** Нийлүүлэлтийн сүлжээг албажуулахад бичил уурхайгаар олборлосон ашигт малтмалын орон нутгийн, бүсийн болон үндэсний хэмжээнд эдийн засгийг бэхжүүлэх, амьжиргааны түвшинг сайжруулахад оруулдаг хувь нэмэр мэдэгдэхүйцээр нэмэгдсэн байна.
- **Мэдлэг хуваалцах ба Бичил уурхайн талаар дэлхийн хэмжээний бодлогын хэлэлцүүлэг:** Монгол Улсын бичил уурхайтай холбоотой өөрсдийн бий болгосон болон олон улсын сайн туршлагад хувь нэмэр оруулах, түүнээс суралцах, нэвтрүүлэх; Монгол Улсын хүрсэн амжилтыг үндэсний хэмжээнд бататгах;



© SDC / SAM project

ХҮРСЭН ҮР ДҮН

Төсөл хэрэгжиж эхэлснээр Бичил уурхайн салбарт олон дэвшил гарсан бөгөөд түүнээс дурдвал:

- Бичил уурхайн эрх зүйн орчин бий болж Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогод бичил уурхайн асуудал тусгагдсан;
- Бичил уурхайг албажуулснаар төрөөс бичил уурхайчдад үзүүлэх үйлчилгээ сайжирсан;
- Бичил уурхайчдын эрүүл мэнд, нийгмийн даатгалд хамрагдалт нэмэгдсэн;
- Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны нөхцөл байдал сайжирч, осол аваарын тоо буурсан;
- Эрдэнэсийн санд тушаасан алтны хэмжээ үлэмж нэмэгдсэнээр Ашигт малтмал ашигласны төлбөрөөс хуримтлагдсан орлого нэмэгдсэн;
- Бичил уурхайчид зохион байгуулалтад орсноор орон нутгийн удирдлага болон уул уурхайн компаниуд бичил уурхайчдын хамтын ажиллагаа сайжирсан;
- Ази тивд анх удаа Монгол Улсын бичил уурхайчдын байгууллага Шударга олборлолтын гэрчилгээ авсан;
- Монгол Улсаас анх удаа "ХАМОДХ" ТББ экологийн шударга олборлолтын аргаар олборлосон нэг килограмм алтыг дэлхийн зах зээлд амжилттай экспортлосон;
- Мөнгөн усгүй, байгаль орчинд хал багатай хүдэр боловсруулах технологи нэвтрүүлсний үр дүнд улсын хэмжээнд хоёр цех албан ёсоор үйл ажиллагаа эрхэлж байна;
- Хүний эрхийн мэдлэг, мэдээллийг түгээн дэлгэрүүлснээр бичил уурхайчид өөрсдийн эрхийг хамгаалах чадвартай болсон байна.

Хамтран хэрэгжүүлэгч түншүүд:

- Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
- Байгаль орчин, аялал жуулчлалын яам
- Сангийн яам
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
- Эрүүл мэндийн яам
- Хүний эрхийн үндэсний комисс
- Ашигт малтмал, газрын тосны газар
- Монголбанк
- Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар
- Татварын ерөнхий газар
- Онцгой байдлын ерөнхий газар
- Үнэт металлын сорьцын хяналтын газар
- Нийгмийн халамж үйлчилгээний ерөнхий газар
- Үндэсний статистикийн хороо
- Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
- Аймгийн Засаг даргын тамгын газрууд
- Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо
- ТББ болон иргэний нийгмийн байгууллагууд
- Бичил уурхайн ТББ-ууд болон нөхөрлөлүүд

Холбоо барих:

Тогтвортой бичил уурхай төсөл

Монгол Улс, Улаанбаатар хот
Элчингийн гудамж, 1-р хороо
Скай Плаза Бизнес төв


- +976 11 328848
- +976 11 322415
- info@sam.mn
- www.sam.mn
- Монголын бичил уурхай
- ASM_Mongolia

ИНФОГРАФИК: 2013-2016 ОНУУДЫН ХАРЬЦУУЛСАН ТОО БАРИМТ


Монголбанканд борлуулсан алтны хэмжээ:




Бичил уурхайн зориулалтаар олгосон газар:²



Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр:



Бичил уурхайн албажуулалтын үйл явц:



Швейцарийн ЭСЯ-ны Хамтын ажиллагааны газар

Монгол Улс, Улаанбаатар хот
Элчингийн гудамж, 1-р хороо
Скай Плаза Бизнес төв
Ш/Х 37, Улаанбаатар 14210

- +976 11 331422
- +976 11 331420
- ulaanbaatar@eda.admin.ch
- www.swiss-cooperation.admin.ch/mongolia
- Swiss Cooperation in Mongolia